



“ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
САН”-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ОД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.07 № 2/28 ЧАТ-САТ/2014/15/СН А-ТНТЗ

Зөрчлийг арилгуулах тухай

“Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-ийн 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нийт байгууллага, аж ахуйн нэгж хувь хүнд өгөх 78,822.1 сая төгрөгийн өглөгөөс 45,879.9 сая төгрөг буюу 58.2 хувийн өглөг тооцоо нийлж баталгаажсан, 32,940.9 сая төгрөг буюу 41.8 хувийн өглөг баталгаажаагүй байна. Үүнд 27,311.1 сая төгрөг 2008 оноос хойш үүссэн “Монгол улсыг хөгжүүлэх сан”-ийн өр бөгөөд 2012.09.04-ний өдрийн гэрээ дүгнэсэн актаар 29,115.5 сая төгрөгөөр тогтоосон нь балансын дүнгээс зөрүүтэй. 2008 оноос хойш эхний санхүүжилт хийгдсэн 30,269.3 сая төгрөгөөс үнийн хөнгөлөлт, хорогдол, хадгалалтын зардал гэх мэт 18,558.6 сая төгрөгөөр буурсан тооцоог хасаж дахин тооцоо нийлэхээр үндэслэл тооцоолоо гарган Сангийн яаманд 2 удаа албан хүсэлт хүргүүлсэн боловч шийдэгдээгүй.
2. Нийт харилцагч байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнээс авах 86,570.3 сая төгрөгийн авлагаас 17,592.2 сая төгрөг буюу 20.3 хувийн авлага тооцоо нийлж баталгаажсан, 68,978.1 сая төгрөг буюу 79.7 хувийн авлага баталгаажаагүй байна. Өглөг, авлагын насжилтын судалгаа гаргадаггүй, найдваргүй авлагын нөөцийн сан бүрдүүлээгүй, авлагыг эргэн төлөлтийн хугацаагаар ангилан баланс тайланд тусгаагүй.
3. Газар тариалангийн тоног төхөөрөмжийн зээлийн урьдчилгаа төлбөрийн төвлөрүүлэлтийг 4,026.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн зээлийн борлуулалтаас түүвэрлэн шалгахад 738.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөс гэрээний дагуу төвлөрүүлэх 195.2 сая төгрөгийг төвлөрүүлээгүй. Сайдын тушаалын дагуу тоног төхөөрөмж зээлээр худалдан борлуулахад ТЭДСан зээлийн гэрээ хийдэг боловч зээлийн гэрээ хийхэд зээлдэгчид тавих нэгдсэн шалгуур, журам байхгүй.
4. Цалин хөлс, ндш зардал 66,1 сая, эд хогшил худалдан авах зардал 39,1 сая, хөрөнгө оруулалт 345.6 сая, гадаад дотоод томилолт, сургалт семинар 53.0 сая, урсгал засвар 78.5 сая, нэг удаагийн тэтгэмж буцалтгүй тусламж 29.9 сая төгрөг нийт 612.2 сая төгрөгөөр урсгал зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлсэн.
5. Төсөв тусгалгүй хөрөнгө оруулалтаар барилга байгууламжид 52.2 сая, тоног төхөөрөмж 21.4 сая, програм хангамж 24.3 сая, тавилга 37.4 сая, авто тээврийн хэрэгсэл 210.2 сая нийт 345,6 сая төгрөгийн хөрөнгө олж бэлтгэсэн. “Есөн хангай” хувийн аудитын компаниас 43.0 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээ авч 40.0 сая төгрөг шилжүүлсэнээр зориулалт бусаар зарцуулсан.


Энэ нь:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-т "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэжзаасныг зөрчсөн, Үйлдвэр хөдөө аж ахуйн салбарын бодлого, горим 4.2, 4.6 дах заалтыг мөрдөж ажиллаагүй
2. ҮХААЯамны сайдын 2012.07.03№ А/113 тушаалын 3-т зааснаар "Барааны нийлүүлсэн үнийн дүнгийн 1 хувиар үйл ажиллагааны зардлыг төвлөрүүлж, 30хувийн урьдчилгаа төлбөртэй, үлдэгдэл төлбөрийг дараагийн 7 жилд төлөх нөхцлөөр, батлагдсан хуваарын дагуу аж ахуйн нэгж, иргэн, байгууллагатай зээлийн гэрээ байгуулж борлуулан Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дансанд төвлөрүүл" гэсэн тушаалыг мөрдөж ажиллаагүй
3. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2дах заалт "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Монгол Улсын Засгийн Газрын тусгай сангийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалт "Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно"гэсэн заалтыгтус тус зөрчсөн, Монгол улсын засгийн газрын тогтоол №324 МУ-ын 2013 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай, ҮХААЯамны сайдын А/144 тоот тушаал, ҮХААЯамны ТЭДС-ийн удирдах зөвлөлийн №21 тоот тогтоол, ҮХААЯамны төрийн нарийн бичгийн даргын А/421тоот зардал хэмнэх тухай тушаал зэргийг мөрдөөгүй.
4. Монгол Улсын Засгийн Газрын Тусгай сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг мөрдөж ажиллаагүй.

"Төрийн аудитын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Өр авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, насжилтын судалгаа гаргах, авлагыг төлөгдөх хугацаагаар нь баланс тайланд тусгах, найдваргүй авлагын нөөцийн сан үүсгэх, "Монгол улсыг хөгжүүлэх сан"-ийн улаан буудайн нөөц сан бүрдүүлэх зээлийн санхүүжилтыг баланс тайланд тусгагдсан 27,311.1 сая төгрөгийн өглөгийг Сангийн яамтай тооцоо нийлэн баталгаажуулах, тоног төхөөрөмжийн зээлийн гэрээнд заасан урьдчилгаа төлбөрөөс төвлөрүүлээгүй 195.2 сая төгрөгийг нөхөн төвлөрүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийх, зориулалт бус зардал гаргахгүй байхарга хэмжээг авч биелэлтийг 2014 оны 7 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "ТЭДС"-ийн Гүйцэтгэх захирал Д.Од, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Ундарьяа нарт хариуцуулав.

Аудитор



Б.Сэржмядаг